

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 1 дүгээр сарын 15

№ 02

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2018 оны 1 дүгээр сарын 15-ний өдрийн 08 цаг 30 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг даргын С.Насанбат удирдаж, хуралд нийт 23 гишүүд оролцож. Цэргийн штабын дарга хурандаа Ц.Энхтөр Батлан хамгаалахын яаманд томилолттой хуралдааны ирц 95.83 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, агентлагийн дарга нар 7 хоногийн ажлын тайлан, холбогдох мэдээ, мэдээлэл, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Аймгийн Засаг даргын С.Насанбат:

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
1.	Хэлтэс, агентлагийн дарга нар аливаа томилолт, сургалт сурталчилгаа, томоохон төсөл, арга хэмжээний ажлын хэсэгт орох, ажил үүргийн талаарх мэдээллийг шуурхай өгч мэдээлэлж байх	Бүх хэлтэс, агентлагийн дарга нар
2.	Цагаан сарын баярын арга хэмжээг угтаж Цагдаагийн газрын эргүүл хамгаалалтыг эрчимжүүлэх, шөнийн эргүүлийг чангатгах, зам тээврийн осол аваар гарах, хулгайн гэмт хэрэг нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан компьютер тоглоомын газрын, сурагчдын амралт чөлөөт цагаа өнгөрөөх газруудын хяналт, шалгалтыг чангатгах	Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар
3.	Постуудын хяналт, шалгалтыг чангатгах, малын хулгай, хулгайн мах, мах, махан бүтээгдэхүүнд хяналт, шалгалт хийх, хуваарь гаргах	Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар
4.	Цагаан сарын баярын арга хэмжээний хүрээнд орон нутгийн байгууллагуудаас ямар арга хэмжээ зохион байгуулж байна. Аймаг хэрхэн хамтран ажиллах вэ? Мөн Мэдээлэл технологийн албанд урьдчилан мэдээлэл өгөх	АЗДТГ-ын хэлтсүүд, Мэдээлэл технологийн алба
5.	Сайдтай байгуулах гэрээний төслийг урьдчилан танилцуулж, хянуулах аймгаас явуулсан гэрээний төсөл, яаманд хүргүүлсэн гэрээний төсөл зөрөхгүй байхад анхаарах	АЗДТГ-ын хэлтсүүд
6.	Цагаан сарын баяртай холбогдуулан шөнө, оройн цагаар аж ахуйн нэгж байгууллага дээрээ өвчүү, ууц чанадаг асуудал гардаг гал түймрээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	Онцгой байдлын газар
8.	Шатахууны нөөц бүрдүүлэх, цаг агаарын урьдчилсан мэдээллийг иргэдэд сайтар өгөх	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
9.	Гар дээрх хүнсний худалдаа, хугацаа хэтэрсэн бараа бүтээгдэхүүний худалдаа, бэлэн боловсруулсан хоол, хүнсний	Мэргэжлийн хяналтын газар

	үйлдвэрлэлт, аж ахуйн нэгж байгууллагууд үйлчилгээний газруудад хяналт, шалгалт хийх, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлт, борлуулалтын цэгүүд, гэрийн нөхцөлд хийж байгаа хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх	
10.	СӨХолбоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, ДСЦТС ХК-ны удирдлагуудтай уулзах СӨХ-ийн төлбөрийг цахилгааны төлбөртэй хамт авах ажлыг судлах	Захирагчийн алба
11.	НААҮГазрын автомашины парк шинэчлэлтийг хийх	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
12.	Дархан-Уул аймгийн 2020 он хүртэлх хотын ногоон байгууламжийн зураг гаргах хэрэгтэй байна. Алсыг харсан бодлого, төлөвлөлт хэрэгтэй байна. Зураг гаргаж танилцуулах	Захирагчийн алба
13.	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй газрууд байна. Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг чиглэл бүрийг ажил болгож хийж гүйцэтгэх шаардлагатай байна.	Бүх хэлтэс, агентлаг
14.	Авто тээврийн мастер төлөвлөгөө, Дархан-Уул аймгийн хэтийн төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөг дуусгах, авто тээврийн байгууллагуудад хяналт байхгүй байна. Нийтийн тээврийн үйлчилгээг журамд оруулах, цэгцлэх хэрэгтэй байна.	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
15.	Худалдан авах ажиллагаа нээлттэй ил тод, шударга байх, оролцож байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг дуудаж уулзалт хийх, мэдээлэл, зөвлөмж өгөх	Орон нутгийн өмчийн газар
16.	ХОХБТХэлтэс энэ онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг ил болгох, иргэд олон нийтэд мэдээлэл өгөх, мэдээллийг тогтмол явуулах	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
17.	Нийгмийн бодлогын чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг яаралтай зарлах, журам боловсруулах, БСУБайгууллагуудыг оролцуулах сургууль, цэцэрлэгүүдтэй амьд харилцаа үүсгэх	Нийгмийн бодлогын хэлтэс
18.	Мал бүхий иргэдийг хотоос гаргах ажлын явц, тооцоо, судалгааг танилцуулах, Малын удмын сангийн цогцолбортой холбож аймагтаа эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх том бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарах	Дархан сумын Засаг дарга
19.	ЗГХЭГазраас цахим хурлын хөтөлбөр ирсэн ХОХБТХэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг гарч бизнесийн байгууллагуудыг цахим хуралд оролцуулах ажлыг зохион байгуулах	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
20.	Хэлтсийн дарга нарын хурал хийх	Аймгийн Засаг даргын Тамгын газар
21.	Хүүхдийн өвчлөлд анхаарах	Нийгмийн бодлогын хэлтэс
22.	7 хоногийн нүүрсний нөөцтэй уурхайн талаар мэдээлэл гарсан Шарын голын уурхайн нөөцийг анхаарах нүүрсний нөөцийн сүүлийн 7 хоногийн мэдээг авч танилцуулах	Захирагчийн алба

Хурал 10 цаг 26 минутад дуусав.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ

2018 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2018 оны 01 дүгээр сарын 19

№ 02

Дархан-Уул аймаг

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хэрэгжилт
1.	Хэлтэс, агентлагийн дарга нар аливаа томилолт, сургалт сурталчилгаа, томоохон төсөл, арга хэмжээний ажлын хэсэгт орох, ажил үүргийн талаарх мэдээллийг шуурхай өгч мэдээлэлж байх	Бүх хэлтэс, агентлагийн дарга нар	Аймгийн ЗДТГ-ын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу архив, бичиг хэргийн эрхлэгч томилолт олгох хуудсыг ЗДТГ-ын даргын зөвшөөрөлөөр олгож байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” -ийн сургалтанд 2018 оны 01 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд хамрагдсан. Тус сургалтын удирдамжийг аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболдод танилцуулж батлуулан томилолтоор ажилласан болно.
2.	Цагаан сарын баярын арга хэмжээг угтаж Цагдаагийн газрын эргүүл хамгаалалтыг эрчимжүүлэх, шөнийн эргүүлийг чангатгах, зам тээврийн осол аваар гарах, хулгайн гэмт хэрэг нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан компьютер тоглоомын газрын, сурагчдын амралт чөлөөт цагаа өнгөрөөх газруудын хяналт, шалгалтыг чангатгах	Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар	2018 оны сар шинийн баярыг угтан Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор өдөр шөнийн явган эргүүл, хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэлийн байдал, сонор сэрэмжийг дээшлүүлэх чиглэлээр удирдлагын зүгээс тогтмол үүрэг чиглэл өгч үр дүнг тооцон ажиллаж байна. Мөн гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор баг хариуцсан хэсгийн байцаагч нар багийн Засаг дарга нартай хамтран нийтийн болон урамшилт эргүүлийг ажиллуулах, хүн ихээр төвлөрдөг худалаа үйлчилгээний газруудаар халаасны хулгайн хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааруулга сэрэмжлүүлэг тараах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Интернет цахим тоглоомын газруудад үйлдэгдэн гарч байгаа зөрчлүүдийг илрүүлэх таслан зогсоох чиглэлээр баг хариуцсан хэсгийн байцаагч нар ГБХХГХУС байцаагч нартай хамтран үзлэг шалгалт хийн нийт цагийн хуваарь хэтрүүлэн

			ажилласан 4 зөрчлийг илрүүлэн арга хэмжээ тооцон холбогдох албан тушаалтанд шилжүүллээ.
3.	Постуудын хяналт, шалгалтыг чангатгах, малын хулгай, хулгайн мах, мах, махан бүтээгдэхүүнд хяналт, шалгалт хийх, хуваарь гаргах	Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтолыг үндэслэн Мал эмнэлэг үржлийн газрын даргын 2017 оны А/46 дугаар тушаалаар малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мах, бүтээгдэхүүн, түүхий эдийг малын халдварт өвчин гараагүй, халдварын голомтгүй вакцинжуулаагүй бүс нутгаас бэлтгэн нийлүүлэх, нөөцлөх, улмаар олон улсын мал эмнэлэг хорио цээрийн шаардлагад нийцсэн мах, махан бүтээгдэхүүн, түүхий эдийг бэлтгэн экспортонд гаргах зорилгоор 2017.11.30-аас 2018.02.01 өдөр хүртэл Мал эмнэлгийн хяналтын цэг байгуулах ажлын хүрээнд аймгийн МХГ, ХХААГ, Авто тээврийн төв, ЦГ хамтран УБ-ДА чиглэлийн 40 пост дээр аймгийн Засаг даргын орлогчийн баталсан хуваарийн дагуу дагуу үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч нарт хяналт шалгалт зохион байгуулж байна.
4.	Цагаан сарын баярын арга хэмжээний хүрээнд орон нутгийн байгууллагуудаас ямар арга хэмжээ зохион байгуулж байна. Аймаг хэрхэн хамтран ажиллах вэ? Мөн Мэдээлэл технологийн албанд урьдчилан мэдээлэл өгөх	АЗДТГ-ын хэлтсүүд, Мэдээлэл технологийн алба	Цагаан сарын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахтай холбогдуулан аймгийн МТА-наас Цагаан сарын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай мэдээ, мэдээллийг сайтууд болон facebook хуудсанд байршууллаа.
5.	Сайдтай байгуулах гэрээний төслийг урьдчилан танилцуулж, хянуулах аймгаас явуулсан гэрээний төсөл, яаманд хүргүүлсэн гэрээний төсөл зөрөхгүй байхад анхаарах	АЗДТГ-ын хэлтсүүд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар 2018 онд байгуулах гэрээний төсөлтэй танилцан харьяа агентлагуудаас ирсэн саналыг нэгтгэн 4 хөтөлбөрийн заалтад өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн. Үүнд: ➤ “Хөтөлбөр 1”-ийн 1.3 дахь хэсэгт Нийт гэр бүл, ахмад настны 40 хувьд хүрч үйлчилсэн байна гэсэн хүрэх түвшинг 25 хувь, нийт залуучуудын 40 хувьд хүрч үйлчилсэн байх хүрэх түвшинг 30 хувь болгох. ➤ Хөтөлбөр 2”-ын 2.4дэх хэсэгт тусгасан Нийгмийн даатгалын

			<p>бууруулах шимтгэлийн өр, авлагын хэмжээг 4,127,536.8 гэж тусгасныг 3,323,037.4 мянган төгрөг болгох.</p> <ul style="list-style-type: none"> ➤ “Хөтөлбөр 3”-ын 3.1 дэх хэсэгт Шинээр бий болох ажлын байрны тоог 1450 гэж заасныг 1300 болгож, 3.4 дэх хэсгийн хамрагдах хүний тоог 6894 гэж заасныг 6744 болгох ➤ “Хөтөлбөр”4-ийн 4.1 дэх хэсгийн МСҮТ, Политехникийн коллеж төгсөгчдөөс ажлын байртай болсон иргэдийн тоог нийт төгсөгчдийн 70%-аас доошгүй ажлын байраар хангагдсан байна гэж тусгасныг 60% болгон өөрчлөх саналыг тус тус хүргүүлсэн. <p>Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдтай байгуулах гэрээнд дараах саналыг хүргүүлсэн.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Боловсрол,соёл,шинжлэх ухаан, спортын бөгөөд төсвийн Ерөнхийлөн захирагч болон Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2018 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээнд өөрчлөлт оруулах. Урьд нь 3.7.10-т Бага боловсролыг албан сургалтаар эзэмшүүлэх бодлого баримтлан үр дүнтэй хэрэгжүүлэх. Ийм заалтыг өөрчилж 3.7.10-т багшийн хөдөлмөрийг бодитой үнэлэх, багшид олгох “Үр дүнгийн урамшуулал”-ыг ажлын үр дүнгээр оновчтой, ил тод олгоход чиглэсэн Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн /багшийн/ сургалтын чанар, хүртээмжийн үр дүнг индексээр дүгнэх саналыг хүргүүлсэн.
6.	Цагаан сарын баяртай холбогдуулан шөнө, оройн цагаар аж ахуйн нэгж байгууллага дээрээ өвчүү, ууц чанадаг асуудал гардаг гал түймрээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	Онцгой байдлын газар	Хяналт шалгалт зохион байгуулах удирдамжийг батлуулахаар ажиллаж байна. Шалгалтыг 2018.02.08-13-ны хооронд зохион байгуулна.
8.	Шатахууны нөөц бүрдүүлэх, цаг агаарын урьдчилсан мэдээллийг иргэдэд сайтар өгөх	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн	Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдах үед болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээг түргэн шуурхай

		хэлтэс	хүргэх зорилгоор аймаг, сумын Онцгой комисс, малчид тээвэрчид, төрийн болон олон нийтийн байгууллагад нийт 1931 үүрэн телефоны хэрэглэгчдэд 91120090, 91120091, 91120092 дугааруудаас багц мессежийг хүргэн ажиллаж байна.
9.	Гар дээрх хүнсний худалдаа, хугацаа хэтэрсэн бараа бүтээгдэхүүний худалдаа, бэлэн боловсруулсан хоол, хүнсний үйлдвэрлэлт, аж ахуйн нэгж байгууллагууд үйлчилгээний газруудад хяналт, шалгалт хийх, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлт, борлуулалтын цэгүүд, гэрийн нөхцөлд хийж байгаа хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх	Мэргэжлийн хяналтын газар	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй байна.
10.	СӨХолбоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, ДСЦТС ХК-ны удирдлагуудтай уулзах СӨХ-ийн төлбөрийг цахилгааны төлбөртэй хамт авах ажлыг судлах	Захирагчийн алба	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлсэн боловч өөр тайлан ирүүлсэн
11.	НААҮГазрын автомашины парк шинэчлэлтийг хийх	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	НААҮГазрын автомашины парк шинэчлэлтийг хийх ажлын хүрээнд 2 ширхэг хог тээврийн шахдаг авто машиныг авахаар ОНӨГазарт 2018 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр холбогдох бичиг баримтыг хүргүүлсэн.
12.	Дархан-Уул аймгийн 2020 он хүртэлх хотын ногоон байгууламжийн зураг гаргах хэрэгтэй байна. Алсыг харсан бодлого, төлөвлөлт хэрэгтэй байна. Зураг гаргаж танилцуулах	Захирагчийн алба	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлсэн боловч өөр тайлан ирүүлсэн
13.	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй газрууд байна. Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг чиглэл бүрийг ажил болгож хийж гүйцэтгэх шаардлагатай байна.	Бүх хэлтэс, агентлаг	2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаас 22 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 2 байгууллага 4 үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй үүрэг даалгаврын хэрэгжилт 81.81 хувьтай байна.
14.	Авто тээврийн мастер төлөвлөгөө, Дархан-Уул аймгийн хэтийн төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөг дуусгах, авто тээврийн	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн	Автотээврийн мастер төлөвлөгөөг Улаанбаатар хотод хийлгүүлэхээр гүйцэтгэгч байгууллагад гэрээг хүргүүлээд байна. Дархан-Уул аймгийн хэтийн

	байгууллагуудад хяналт байхгүй байна. Нийтийн тээврийн үйлчилгээг журамд оруулах, цэгцлэх хэрэгтэй байна.	хэлтэс	төлөвлөгөөг хийлгүүлэх ажил сангийн яаман дээр маргаан үүссэн тул хүлээгдэж байна. 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Дархан Орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын байранд нийтийн тээврийн үйлчилгээний журам, үйл ажиллагааг сайжруулах талаар хэлтсийн дарга С.Баясгалан холбогдох албан хаагчидтай хурал хийж нийтийн тээврийн үйлчилгээний чанарт үүсээд буй асуудлын шалтгааныг илрүүлэн нийтийн тээврийн үйлчилгээ явуулдаг 3 байгууллагыг холбогдох журмын дагуу автотээврийн хяналтын улсын байцаагч ажиллаж буй Дархан-Уул аймаг дахь “Авто тээврийн төв”-д шилжүүлэхээр эхний байдлаар шийдвэрлэсэн байна.
15.	Худалдан авах ажиллагаа нээлттэй ил тод, шударга байх, оролцож байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг дуудаж уулзалт хийх, мэдээлэл, зөвлөмж өгөх	Орон нутгийн өмчийн газар	2018 оны 01 дүгээр сарын 17-ний өдөр аймгийн ЗДТГазрын хурлын танхимд болсон Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан аймгийн Засаг даргын үйлдвэр эрхлэгчидтэй уулзах цахим хуралд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагад мэдээлэл хийсэн. -Орон нутгийн өмчит 61 байгууллагад 2018 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 15 цагт АЗДТГазрын хурлын танхимд цахим худалдан авалтын зохион байгуулалт, худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг цахим системд шивэх талаарх сургалтыг тус тус зохион байгуулсан.
16.	ХОХБТХэлтэс энэ онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг ил болгох, иргэд олон нийтэд мэдээлэл өгөх, мэдээллийг тогтмол явуулах	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	ДУА-ийн ЗДТГ-ын Мэдээлэл технологийн албанд хэлтсийн дарга С.Баясгалан тодруулга ярилцлага өгч Дарханы 4 телевиз, олон нийтийн сүлжээнд 2018 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын тухай иргэдэд ил тод нээлттэй мэдээлэл өгсөн
17.	Нийгмийн бодлогын чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг яаралтай зарлах, журам боловсруулах, БСУБайгууллагуудыг оролцуулах сургууль, цэцэрлэгүүдтэй амьд харилцаа үүсгэх	Нийгмийн бодлогын хэлтэс	2017 онд Нийгмийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тайлан, журмыг боловсруулан Засаг даргын орлогчид танилцуулахад бэлэн болоод байна. 2018 оныг “Ахмадын жил” болгосонтой холбогдуулан төсөл хөтөлбөрийг ахмадын оролцоог дэмжихэд зориулах саналтай байна.
18.	Мал бүхий иргэдийг хотоос гаргах ажлын явц, тооцоо, судалгааг танилцуулах, Малын удмын сангийн	Дархан сумын Засаг дарга	Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Дархан сумын гэр хорооллын бүсэд байгаа мал, туслах аж ахуйг хотын төвөөс

	цогцолбортой холбож аймагтаа эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх том бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарах		гаргах ажлыг зохион байгуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсэг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр эхний хурлаа хийж авч хэрэгжүүлэх анхан шатны хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу чиглэл бүрдээ ажлаа нарийвчлан зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан танилцуулахыг ажлын хэсгийн дарга тус сумын Засаг дарга Б.Азжаргал ажлын хэсэгт үүрэг болголоо. “Дархан сумын гэр хорооллын бүсэд байгаа мал, туслах аж ахуйг хотын төвөөс гаргах ажлын хүрээнд 1,2,3,5,6,7,8,15-р багуудын мал, туслах аж ахуйтай өрхийн судалгааг багуудаас авч нэгтгэсэн гаргалаа. Судалгаагаар тус багуудад 374 өрхийн 8317 толгой мал, 96 өрхийн 8983 тэжээвэр амьтан байгаагаас эхний ээлжинд хотын төвөөс гаргах 5,6,7,8,15-р багийн 141 өрхийн 3551 толгой мал байна. Үүнээс 141 өрхийн малыг тоо, толгойн бүлэглэлээр харуулбал 1-5 малтай 30 өрх, 6-10 малтай 37 өрх, 11-20 толгой малтай 31 өрх, 21-30 малтай 12 өрх, 31-40 малтай 5 өрх, 41-50 малтай 3 өрх, 50-100 малтай 14 өрх, 100-дээш малтай 9 өрх байна.
19.	ЗГХЭГазраас цахим хурлын хөтөлбөр ирсэн ХОХБТХэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг гарч бизнесийн байгууллагуудыг цахим хуралд оролцуулах ажлыг зохион байгуулах	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжлийн газар хамтран 2018 оны 01 дүгээр сарын 17-ний өдөр зохион байгуулсан Аж үйлдвэрийн нэгдсэн тооллогын нээлт, цахим хуралдаанд тооллого зохион байгуулах ажлын хэсгийн 13 гишүүн, 60 үйлдвэрлэгчдийг оролцуулав. Аж үйлдвэрийн нэгдсэн тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг байр, шаардлагатай компьютер, техник, тоног төхөөрөмж, интернет, холбооны хэрэгслээр хангах, 2018 оны 04 дүгээр сарны 17-ний өдрийн дотор дуусгаж дүн мэдээг нэгтгэсэн байх үүрэг өгөгдсөн.Мөн сумдын Засаг дарга нар дэд ажлын хэсэг байгуулж орон нутагтаа тооллогын ажлыг зохион байгуулах үүрэгтэй.
20.	Хэлтсийн дарга нарын хурал хийх	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Аймгийн ЗДТГ-ын даргын өрөөнд 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 15:00 цагт хэлтсийн дарга нарын хурал хийж цаг үеийн асуудлаар хэлэлцэн шийдвэрллээ.
21.	Хүүхдийн өвчлөлд анхаарах	Нийгмийн бодлогын	Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгаар 1 сарын 18-ны байдлаар 85 хүүхэд

		хэлтэс	<p>амбулаториор үзүүлж, 10 хүүхэд хэвтэж, 22 хүүхэд эмнэлгээс гарч, үзүүлсэн 35 хүүхэд байна. Тасагт хэвтэж байгаа 73, үүнээс хүнд өвчтэй- 6 хүүхэд байна.</p> <p>Аймгийн амбулаторийн нийт үзлэгт ТТӨ 4.1%-ийг эзэлж, өмнөх 7 хоногоос 2.9 хувиар бага, сүүлийн 3 жилийн дунджаас 0.5%-иар их байна. Уушгины үрэвсэл, амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (410)-ийн дотор 55 буюу 13.4%-ийг эзэлж, өмнөх долоо хоногоос 2.8%-иар бага байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна. Аймгийн хэмжээнд ТТӨ дуудлаганд 20.2%-тай байгаа нь өмнөх 7 хоногоос 8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. /Нийт 569 үзлэгээс 115 томуугийн өвчлөл байна/</p>
22.	7 хоногийн нүүрсний нөөцтэй уурхайн талаар мэдээлэл гарсан Шарын голын уурхайн нөөцийг анхаарах нүүрсний нөөцийн сүүлийн 7 хоногийн мэдээг авч танилцуулах	Захиаргчийн алба	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлсэн боловч өөр тайлан ирүүлсэн</p>

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ